



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/247


Арвайхээр

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай
тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.6, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн дүн, 2019 оны үндсэн чиглэлийг батлах тухай” тогтоолын 2.3.35 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтан их хэмжээгээр тархсан Баян-Өндөр, Бүрд, Зүүнбаян-Улаан, Өлзийт, Есөнзүйл, Тарагт, Хархорин сумдад микробиологийн аргаар мэрэгч амьтантай тэмцэх ажлыг 2019 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс 5 дугаар сарын 15-ны өдөр хүртлэх хугацаанд зохион байгуулсугай.
2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сумдад хийгдэх бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай микробиологийн аргаар тэмцэх бактержуулсан будааны хэмжээ, зардлын хувиарилалтыг хавсралтаар баталсугай.
3. Мэрэгч амьтантай тэмцэх ажилд иргэд, малчид, малчдын бүлэг хоршоог хамруулж тэднийг мэрэгч устгалын гарын авлага, хөдөлмөр хамгааллын хувцас, шаардлагатай техник хэрэгслээр хангах, сургалт зохион байгуулах болон цаг агаарын саатлаас бусад тохиолдолд ажил саатахгүй байх бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээг авч, хууль, журмын дагуу хяналт тавьж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү ажлын явц, үр дүнг тооцож, арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир), ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн) нарт даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100551

Аймгийн Засаг даргын 2019 оны ...
 дугаар сарын ... ны өдрийн ... дугаар
 захирамжийн хавсралт



**СУМДЫН БЭЛЧЭЭРИЙН ХӨНӨӨЛТ МЭРЭГЧ АМЬТАНТАЙ
 ТЭМЦЭХ ТАЛБАЙН ХЭМЖЭЭ, ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ**

д/д	Сум, байгууллагын нэр	Мэргэчтэй тэмцэх бактержуулсан будаа /мянган тонн/		Нийт санхүүжилт /мянган төгрөг/	Зарцуулах зориулалт /мянган төгрөг/	
		Улсын төсвөөс	Орон нутгаас		Оготно устгалд оролцсон малчид, хөдөлмөр хамгааллын хувцас, авто машин, мотоциклын шатахууны зардал	Бактержуулсан будааны үнэ
1	Баян-Өндөр	10.0	1.0	7200.0	3200.0	4000.0
2	Бүрд	7.0	1.0	5040.0	1040.0	4000.0
3	Зүүнбаян-Улаан	12.0	1.0	8640.0	4640.0	4000.0
4	Өлзийт	10.0	1.0	7200.0	3200.0	4000.0
5	Есөнзүйл	7.0	1.0	5040.0	1040.0	4000.0
6	Тарагт	7.0	1.0	5040.0	1040.0	4000.0
7	Хархорин	7.0	1.0	5040.0	1040.0	4000.0
8	Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар			Техник хяналтын зардал 4800.0		
Дүн		60.0	7.0	48000.0	15200.0	28000.0